



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН

- ❖ Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл
- ❖ Түүх, соёлын үл хөдлөх дурсгал,
- ❖ Соёлын биет бус өв

Улаанбаатар
2021 он

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3-4
Нэгдүгээр бүлэг. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЭЛ	5-13
Хоёрдугаар бүлэг. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЭЛ	14-25
Гуравдугаар бүлэг. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН МЭДЭЭЛЭЛ	26-30

ТАНИЛЦУУЛГА

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 23.2, “Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 2.3-т заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тайланг музей болон холбогдох байгууллага, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сангаас авч, нэгтгэх ажил жил бүр хийгдэж ирлээ.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны тайлан ирүүлэх тухай албан бичгийг 21 аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, нийслэлийн Соёл, урлагийн газар, төрийн өмчийн 12 музей, Улаанбаатар хотын музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Үндэсний номын сан, Монголбанкны Эрдэнэсийн сан, МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль, Улаанбаатарын Их сургууль, Ховд Их Сургууль, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа, Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Монголын БШТөв Гандантэгчэнлин хийд нийт 48 байгууллагад хүргүүлснээс Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Монголын БШТөв Гандантэгчэнлин хийд, Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгээс хариу ирүүлээгүй. Тайлан ирүүлсэн 45 байгууллагаас 27 байгууллага тайлангаа хугацаандаа (2 дугаар сарын 15-ны дотор) ирүүлсэн бол (цахим хэлбэрээр ирүүлснийг тооцсон болно) 18 байгууллага хугацаандаа ирүүлээгүй байна. Тайланг дараах маягтаар авсан болно. Үүнд:

Аймаг, нийслэлийн соёлын биеийн бүртгэл, мэдээллийн сангаас:

- Маягт №1-А. “Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээлэл”
- Маягт №1-В. “Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээлэл”
- Маягт №1-С. 1/“Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн 2020 оны мэдээлэл”, 2/“Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн, 3/ Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн”, 4/“Аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн”

Байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас:

- Маягт №2. “Улс, аймгийн музей, эрдэм шинжилгээ судалгааны болон шашны байгууллага дахь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны мэдээлэл”
- Маягт №3. “Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгааны ажлын 2020 оны мэдээлэл”

Тайланг соёлын өвийн дараах ангиллыг баримтлан нэгтгэсэн болно. Үүнд:

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллийг Маягт №1-А болон Маягт №2 -оор авч нэгтгэх ажлыг Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Ш.Энхтуяа,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийг Маягт №1-В болон Маягт №3 -аар авч нэгтгэх ажлыг Бүртгэл, мэдээллийн санч Б.Амгаланбат,
- Соёлын биет бус өвийн мэдээллийг Маягт №1-С -ээр авч нэгтгэх ажлыг Бүртгэл, мэдээллийн санч Ж.Насанжаргал нар тус тус гүйцэтгэлээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайланг байгууллагын болон аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас Маягт №1-А. “Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээлэл”, Маягт №2. “Улс, аймгийн музей, эрдэм шинжилгээ судалгааны болон шашны байгууллага дахь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл” тайлангийн маягтаар авч нэгтгэлээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайланг төрийн өмчийн 12 музей, Монголбанкны Эрдэнэсийн сан, аймгийн 23 музей, Улаанбаатар хотын музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Улаанбаатарын Их сургууль, Ховд Их сургууль гэсэн нийт 42 байгууллагаас ирүүлэв. Үүнээс 31 байгууллага нь сан хөмрөгтөө нэмэлт баяжуулалт хийсэн, 11 байгууллагад баяжилт хийгдээгүй тухай мэдээлэл ирсэн. Баяжилт хийгдээгүй байгууллагад: Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Монгол төрийн түүхийн музей, Хөшөө цайдам музей, Үндэсний номын сан, Булган аймгийн музей, Өвөрхангай аймгийн музей, Сэлэнгэ аймгийн музей, ШУА-ын Палеонтологийн хүрээлэн, Ховд аймгийн музей орж байна.

Баяжилт хийгдсэн 31 байгууллагын СӨБМСангийн мэдээлэл:

- Төрийн өмчийн 7 музейд 373 дэсийн 590 ширхэг үзмэрээр баяжилт хийгджээ. Тухайлбал,

Байгалийн түүхийн музей эрдэм шинжилгээ судалгаагаар 210 дэсийн 340 ширхэг үзмэр, Монголын үндэсний музейд Орхон аймгийн Жаргалант сумын “Айрагийн гозгор”, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Хориг уулын монгол булш зэрэг газраас илэрсэн 72 дэсийн 148 ширхэг олдвороор тус тус баяжигдсан. Монголбанкны Эрдэнэсийн сан 2020 онд “Төрц алт”, алтан үсгээр бичсэн “Алтангэрэл судар”, “Их гарын даалин” зэрэг 5 дэсийн 5 ширхэг үзмэрийг худалдаж авсан байна.

- Эрдэм шинжилгээний байгууллагаас ШУА-ын Археологийн хүрээлэн 223 дэсийн 643 ширхэг, “Улаанбаатар” Их сургууль 134 ширхэг, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн 151 дэсийн 396 ширхэг, “Ховд” Их сургууль 16 дэсийн 52 ширхэг, нийт 524 дэсийн 1225 ширхэг олдвороор сан хөмрөгөө баяжуулсан байна. Тухайлбал,

ШУА-ийн Археологийн хүрээлэн Дорнод аймгийн Булган сумын нутаг Тугийн сүм, Ховд аймгийн Дуут сумын Өлөнтийн хадны оршуулга, Бага Гилгэрийн хадны оршуулга, Увс аймгийн Хяргас суманд явуулсан Монгол-Солонгосын “Соёлын өвийн судалгаа шинжилгээ” төсөл, Төв аймгийн Баянцагаан сумын “Чихэртийн зоо”, “Хүйсийн энгэр” зэрэг газрын малтлага судалгаагаас илрүүлсэн олдвороор; “Улаанбаатар” Их сургууль Архангай аймгийн Өлзийт сумын Харганы хөндийн Дөрвөлжин хэмээх газарт орших эртний “Луут хотын туурь”-иас олдвороор тус тус сан хөмрөгөө баяжуулсан байна.

- Аймаг, нийслэлийн 20 музей 448 дэсийн 752 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжуулсан байна. Тухайлбал,

Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс 86 дэсийн 159 ширхэг чулуун зэвсгийн олдворыг шилжүүлэн авсан, тус аймгийн Эрдэнэмандал хийдийн дэд хамба ламаас хийдэд хадгалагдаж байсан 25 шашны эд өлгийн зүйлийг бэлэг хандиваар өгсөн. Мөн 2 үзмэр худалдаж авсан ба үүнд, “Гацуурт” ХХК-ийн захирал Л.Чинбатын хандивласан 10 сая төгрөгөөр уран дархан Балдан-Осорын урласан “Мөнгөн аяга”-ыг, Дархан Г.Эрдэмбилэгийн дарьганга хийцээр урласан “Мөнгөн цом” зэргийг тус тус худалдан авчээ. Төв аймгийн музей 2018-2019 оны тооллогоор дутагдсан 2 үзмэрийн оронд “Дамар”, “Чавир” гэсэн 2 үзмэрийг худалдан авсан, мөн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Сарьдагийн хийдийн малтлагаас гарсан “Цац”, “Тоосго” бүхий 2 дэсийн 103 үзмэрийг шилжүүлэн авч, бэлэг хандиваар 8 дэсийн 9 ширхэг үзмэрийг тус тус авсан байна.

Аймгийн СӨБМСангаас ирүүлсэн мэдээлэл:

- Аймгийн СӨБМСангийн мэдээллээр 10 аймгийн 56 сумын Орон нутаг судлах танхимд нийт 363 дэсийн 371 ширхэг үзмэр нэмэгдсэн.
- Дундговь аймгийн СӨБМСан тус аймгийн Дашгэмпилэн хийдэд хадгалагдаж буй 18 дэсийн 125 ширхэг эд өлгийн зүйлийг шинээр бүртгэх ажлыг зохион байгуулсан.
- Иргэн эд өлгийн зүйлийн бүртгэлийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан болон аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хийж нийт 47 иргэний хүсэлтээр 84 ширхэг эд өлгийн зүйл бүртгэсэн байна. Үүнд, СӨУНБМСан 2 иргэний 3 ширхэг, Баянхонгор аймгийн СӨБМСан 4 иргэний 4 ширхэг, Өмнөговь аймгийн СӨБМС 24 иргэний 25 ширхэг, Увс аймгийн СӨБМСан 17 иргэний 52 ширхэг эд өлгийн зүйлийг тус тус шинээр бүртгэж авсан байна.

Байгууллагын болон аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллээр улсын хэмжээнд улс, аймгийн 31 музей, байгууллага; 10 аймгийн 56 сумдын Орон нутаг судлах танхим, аймгийн 1 хийд нийтдээ 88 байгууллагад 1774 дэсийн 3147 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл нэмэгджээ. Үүнээс: Соёлын өвийн бүртгэлийн Register программд 966 дэсийн 1422 ширхэг үзмэр, RCH бүртгэлийн программд 401 дэсийн 663 ширхэг үзмэрийг (давхардсан тоогоор) оруулж баталгаажуулсан ба үлдсэн 808 дэсийн 1725 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг Register бүртгэлийн программд ороогүй тул Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн баяжилтын нэгдсэн тоон дүнд хамруулах боломжгүй байна.

2020 онд улс, аймгийн 25 музей, 6 аймгийн 26 сумын орон нутаг судлах танхимийн нийт 51 байгууллага 966 дэсийн 1422 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжуулж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн байна.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд 2020 оны баяжилтын нэгдсэн тоон дүнд ороогүй 808 дэсийн 1725 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийн тайлбарыг дараах хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт №1).

Хүснэгт №1

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны

баяжилтын нэгдсэн тоон дүнд ороогүй дурсгалын тухай

Байгууллагын нэр	Үзмэрийн тоо		Тайлбар
	дэс	тоо/ш	
Улс, аймгийн музей			
Монгол цэргийн музей	5	5	Ерөнхий бүртгэлийн дэвтэртээ бичсэн боловч бүртгэлийн программд оруулаагүй
Сүхбаатар аймгийн музей	86	159	Программтай компьютер нь эвдэрсэн /шатсан/
Монголбанкны Эрдэнэсийн сангийн музей	2	2	Тус байгууллага 5 дэсийн 5 ширхэг үзмэрээр баяжилт хийгдсэн боловч 3 дэсийн 3 ширхэг үзмэрийг цахим бүртгэлд оруулсан.
Эрдэм шинжилгээний байгууллага			
ШУА-ийн Археологийн хүрээлэн	223	643	Эдгээр байгууллага нь зөвхөн өөрсдийн дотоод данс “Лабораторийн бүртгэл”, “Олдворын бүртгэл”-дээ авч “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу “Хувийн дугаар” өгч Соёлын өвийн бүртгэлийн Register программд оруулаагүй.
ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн	151	396	
“Улаанбаатар” Их сургууль	134	134	
“Ховд” Их сургууль	16	52	
Орон нутаг судлах танхим			
Баянхонгор аймгийн 3 сумын ОНСТ-ын үзмэр	4	4	Орон нутаг судлах танхимын үзмэрийг тухайн аймгийн СӨБМСан буюу музей дээр цахим программд оруулдаг боловч эдгээр аймгууд программд оруулаагүй байна.
Дорноговь аймгийн 4 сумын ОНСТ-ын үзмэр	10	10	
Дундговь аймгийн 5 сумын ОНСТ-ын үзмэр	32	32	
Завхан аймгийн 18 сумын ОНСТ-ын үзмэр	79	79	
Шашны байгууллага			
Дундговь аймгийн СӨБМСангаас бүртгэсэн тус аймгийн Дашгэмпилэн хийд	18	125	Дундговь аймгийн СӨБМСан тус аймгийн Дашгэмпилэн хийдэд хадгалагдаж буй эд өлгийн зүйлийг шинээр бүртгэж авсан боловч СӨУНБМСангаас шинэ эзэмшигчийн код аваагүй, Register программд оруулаагүй.
Иргэний эд өлгийн зүйл			
СӨУНБМСанд 2 иргэний эд өлгийн зүйл	3	3	Иргэний өмчлөлийн эд өлгийн зүйлийг БСШУ-ны Сайдын 2010 оны 241 тоот тушаалаар батлагдсан маягт бусад холбогдох баримтыг үндэслэн бүртгэж улмаар РСН бүртгэлийн программд оруулан бүртгэлийн код олгогдох юм. Үүний тулд уг программд нэмэлт сайжруулалт хийгдэж байгаа бөгөөд уг ажил харахан дуусаагүй байна. Иймээс цахим бүртгэлд хамрагдаагүй.
Баянхонгор аймгийн СӨБМС 4 иргэний эд өлгийн зүйл	4	4	
Өмнөговь аймгийн 24 иргэний эд өлгийн зүйл	24	25	
Увс аймгийн 17 иргэний эд өлгийн зүйл	17	52	
Нийт	808	1725	

2020 онд Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд нэмэгдсэн (Төрийн өмчийн 6 музей, Монголбанкны Эрдэнэсийн сан, аймаг, нийслэлийн 19 музей, 6 аймгийн 26

Орон нутаг судлах танхим) нийт 51 байгууллагын 966 дэсийн 1422 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийн тоон дүнгийн мэдээллийг хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт №2).

Хүснэгт №2

**Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн
санд 2020 онд нэмэгдсэн үзмэрийн тоон үзүүлэлт**


№	Байгууллагын нэр	Register программд бүртгэсэн дүн		RCH программд бүртгэсэн дүн	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш
Байгууллагын Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан					
Төрийн өмчийн музей-6		366	583	305	511
1	Монголын үндэсний музей	72	148	72	148
2	Байгалийн түүхийн музей	210	340	210	340
3	Монголын уран зургийн галерей	58	69		
4	Монголын театрын музей	20	20	20	20
5	“Хархорум” музей	3	3	3	3
6	Монголбанкны Эрдэнэсийн сан	3	3		
Аймгийн музей-18		362	593	75	128
7	Архангай аймгийн музей	9	11	9	11
8	Баян-Өлгий аймгийн музей	4	6		
9	Баянхонгор аймгийн музей	30	31		
10	Говь-Алтай аймгийн музей	1	4		
11	Говьсүмбэр аймгийн музей	7	9	7	9
12	Дархан-Уул аймгийн музей	36	37	36	37
13	Дорноговь аймгийн музей	2	2		
14	Дорнод аймгийн музей	36	37		
15	Дорнод, “Ялалт” музей	37	43		
16	Дундговь аймгийн музей	65	68		
17	Завхан аймгийн музей	2	2	2	2
18	Орхон аймгийн музей	64	94		
19	Өмнөговь аймгийн музей	11	20		
20	Төв аймгийн музей	12	114		
21	Увс аймгийн музей	10	11	10	11
22	Хөвсгөл аймгийн музей	10	10		
23	Хэнтий аймгийн музей	8	22	8	22
24	Эрдэнэ-зуу музей	15	36		
25	Улаанбаатар хотын музей	3	36	3	36
Аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан					
6 аймгийн 26 сумын ОНСТ		238	246	21	24
1	Говь-Алтай аймгийн 15 сумын ОНСТ	63	68		
2	Дархан-Уул аймгийн 1 сумын ОНСТ	21	24	21	24
3	Өмнөговь аймгийн 4 сумын ОНСТ	30	30		

4	Төв аймгийн 1 сумын ОНСТ	15	15		
5	Увс аймгийн 3 сумын ОНСТ	25	25		
6	Хөвсгөл аймгийн 2 сумын ОНСТ	84	84		
Нийт		966	1422	401	663

Сан хөмрөгийн баяжилтаар нэмэгдсэн 966 дэсийн 1422 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг авсан арга замаар нь ангилбал:

- Худалдаж авсан 80 дэсийн 89 ширхэг,
- Шилжиж ирсэн 74 дэсийн 109 ширхэг,
- Эрдэм шинжилгээ, судалгаагаар 199 дэсийн 418 ширхэг,
- Бэлэг хандиваар ирсэн 597 дэсийн 769 ширхэг,
- Бусад арга замаар 16 дэсийн 37 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг тус тус авсан байна.

Тоон дүнгээс харахад нийт үзмэрийн 61.8%, сумын 26 Орон нутаг судлах танхимд нэмэгдсэн үзмэрийн 99%-ийг бэлэг хандиваар авсан байна. Баяжилтаар нэмэгдсэн үзмэрийн эзлэх хувийг зургаар үзүүлэв (Зураг №1).



Зураг №1. Баяжилтаар нэмэгдсэн 968 дэсийн 1424 ширхэг үзмэрийг сан хөмрөгт авсан арга замаар нь ангилсан үзүүлэлт

Сан хөмрөгийн баяжилтаар нэмэгдсэн 966 дэсийн 1422 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг төрөл зүйлээр ангилбал:

- Байгалийн түүхийн цуглуулга: 232 дэсийн 374 ширхэг,
- Археологийн олдвор: 115 дэсийн 308 ширхэг,
- Түүхийн цуглуулга: 192 дэсийн 244 ширхэг,
- Угсаатны зүйн цуглуулга: 182 дэсийн 189 ширхэг,
- Шашин шүтлэгийн холбогдолтой: 110 дэсийн 160 ширхэг,

- Урлаг, уран сайхны цуглуулга: 135 дэсийн 147 ширхэг байна. Баяжилтаар нэмэгдсэн үзмэрийн төрөл зүйлийн эзлэх хувийг зургаар үзүүлэв (Зураг №2).



Зураг №2. Баяжилтаар нэмэгдсэн 966 дэсийн 1422 ширхэг үзмэрийг 6 төрөл зүйлээр ангилсан үзүүлэлт

Хасагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээлэл. 2020 онд Register бүртгэлийн программаас хасуулахаар хүсэлт гаргасан Монгол цэргийн музей, Төв аймгийн музейн нийт 28 дэсийн 33 үзмэрийн баримтын бүрдлийг судлаж үзсэний үндсэн дээр 22 дэсийн 27 ширхэг үзмэрийг цахим бүртгэлээс хаслаа. Үүнд:

Монгол цэргийн музей давхардаж бичигдсэн 6 дэсийн 8 ширхэг үзмэр, Төв аймгийн музей аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 114 дүгээр тогтоолоор актлагдаж устгахаар шийдвэрлэсэн 22 дэсийн 25 ширхэг үзмэр, үүнээс 16 дэсийн 19 ширхэг үзмэрийг хассан ба үлдсэн 6 дэсийн 6 ширхэг үзмэрийн баримтын бүрдэл дутуу байсан тул хойшлуулаад байна.

Шилжилт хөдөлгөөний мэдээлэл. 2020 онд төрийн өмчийн 10 музей, аймаг, орон нутгийн 18 музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Ховд Их Сургууль нийт 30 байгууллагын 2274 дэсийн 3183 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл шилжилт хөдөлгөөнд орсон байна. Үүнд:

- Дотоодын үзэсгэлэнд 24 байгууллагын 1410 дэсийн 1878 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл хамрагдсан байна. Тухайлбал, Монголын үндэсний музей 4 удаагийн үзэсгэлэнд 160 дэсийн 207 ширхэг, Монголын уран зургийн галерей 7 удаагийн үзэсгэлэнд 255 дэсийн 256 ширхэг, Монгол цэргийн музей 5 удаагийн үзэсгэлэнд 341 дэсийн 376 ширхэг, Сүхбаатар аймгийн музей 3 удаагийн үзэсгэлэнд 107 дэсийн 180 ширхэг үзмэр хамруулсан байна.
- Гадаад орны үзэсгэлэнд 19 дэсийн 20 ширхэг үзмэр оролцсон байна. Энэ нь Хархорум музей 2020 оны 2 дугаар сарын 24-нөөс 3 дугаар сарын 1-ны өдрүүдэд

Япон Улсын Ойта мужийн музейд дэглэгдсэн үзэсгэлэнд оролцуулсан үзмэр болно.

- Судалгаа шинжилгээнд 6 байгууллагын 627 дэсийн 1035 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл,
- Сэргээн засварлалтад 17 байгууллагын 218 дэсийн 250 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл тус тус хамрагдаж шилжилт хөдөлгөөнд орсон байна. Нийт тоон үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт №3).

Хүснэгт №3

2020 онд шилжилт хөдөлгөөнд орсон үзмэрийн тоон үзүүлэлт

№	Байгууллагын нэр	Дотоодын үзэсгэлэнд оролцсон		Гадаадын үзэсгэлэнд оролцсон		Судалгаа, шинжилгээнд хамрагдсан		Сэргээн засварласан		Нийт хамрагдсан үзмэр	
		дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш	дэс	тоо/ш
1	Монголын үндэсний музей	160	207			307	614	119	149	586	970
2	Байгалийн түүхийн музей	10	10							10	10
3	Богд хааны ордон музей	58	74							58	74
4	Дүрслэх урлагийн музей	2	2			2	2	3	3	7	7
5	Чойжин ламын сүм музей							3	3	3	3
6	Монголын уран зургийн галерей	255	256			1	1	3	3	259	260
7	Монголын театрын музей							1	2	1	2
8	“Хархорум” музей			19	20			1	1	20	21
9	Монгол цэргийн музей	341	376			153	192	1	1	495	569
10	ШУА-ийн Археологийн хүрээлэн	19	35							19	35
11	“Хов”д Их Сургууль							52	52	52	52
12	Баян-Өлгий аймгийн музей	21	143							21	143
13	Баянхонгор аймгийн музей	23	23					2	2	25	25
14	Булган аймгийн музей	54	56							54	56
15	Говь-Алтай аймгийн музей							3	3	3	3

16	Говьсүмбэр аймгийн музей							5	5	5	5
17	Дорнод аймгийн музей	50	56							50	56
18	Завхан аймгийн музей	18	48							18	48
19	Орхон аймгийн музей							4	4	4	4
20	Өвөрхангай аймгийн музей	46	56					3	3	49	59
21	Өмнөговь аймгийн музей	6	6					4	4	10	10
22	Сүхбаатар аймгийн музей	107	180							107	180
23	Сэлэнгэ аймгийн музей	90	102							90	102
24	Төв аймгийн музей	33	35					4	4	37	39
25	Увс аймгийн музей	2	2					4	4	6	6
26	Ховд аймгийн музей	10	11							10	11
27	Хөвсгөл аймгийн музей	85	96							85	96
28	Хэнтий аймгийн музей	9	65			1	1			10	66
29	Эрдэнэ-Зуу музей	6	34			163	225	6	7	175	266
30	Улаанбаатар хотын музей	5	5							5	5
Нийт		1410	1878	19	20	627	1035	218	250	2274	3183

ДҮГНЭЛТ

- 2020 оны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллээр улсын хэмжээнд 88 байгууллага нийт 1774 дэсийн 3147 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. Үүнээс Соёлын өвийн бүртгэлийн Register программд орж баталгаажсан нь 966 дэсийн 1422 ширхэг үзмэр байгаа нь Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны баяжилтын албан ёсны нэгдсэн дүн болно.
- Сан хөмрөгийн баяжилтаар нэмэгдсэн нийт үзмэр, эд өлгийн зүйлийн 46 % нь Register программд ороогүй, ялангуяа эрдэм шинжилгээний байгууллагууд болон аймгийн СӨБМСангаас ОНСТанхимын үзмэрийг цахим бүртгэлд оруулах ажил хангалтгүй явагдаж байна.

- 2020 онд баяжилтаар нэмэгдсэн **966** дэсийн **1422** ширхэг үзмэр нь 2019 онд нэмэгдсэн 1410 дэсийн 1672 ширхэг үзмэрээс **68%-иар буурсан** үзүүлэлт гарсан байна.
- 2020 онд баяжилтаар нэмэгдсэн үзмэрийг сан хөмрөгт авсан арга замын үзүүлэлтээс харахад нийт үзмэрийн 61.8%, сумын 26 Орон нутаг судлах танхимд нэмэгдсэн үзмэрийн **99%-ийг “Бэлэг хандив”-аар авчээ**. Энэхүү харьцангуй тогтвортой үзүүлэлт нь цаашид үзмэрийн чанарт сөргөөр нөлөөлөх хандлагатай болохыг анхаарах нь зүйтэй.
- Иргэний өмчлөлийн эд өлгийн зүйлийн бүртгэлийг Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан болон Баянхонгор, Өмнөговь, Увс аймгийн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл сангаас хийж нийт **47 иргэний 84** ширхэг эд өлгийн зүйлийг бүртгэсэн. Энэ нь 2019 онд бүртгэгдсэн 129 иргэний 171 **эд өлгийн зүйлээс 49 %-иар буурчээ**. Цаашид хувь хүний эд өлгийн зүйлийн бүртгэлийн системийг сайжруулах, RCH программын шинэчлэлийг яаралтай шийдвэрлэх шаардлагатай.
- 2020 онд төрийн өмчийн 10 музей, аймаг, орон нутгийн 18 музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, “Ховд” Их Сургууль нийт 30 байгууллагын **2274** дэсийн **3183** ширхэг үзмэр, эд өлгийн зүйл **шилжилт хөдөлгөөнд** оржээ. Энэ нь 2019 онд шилжилт хөдөлгөөнд орж байсан 4901 дэсийн 8704 ширхэг үзмэрээс **46%-иар буурчээ**.
- 2020 оны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тоон үзүүлэлт ийнхүү буурсан нь дэлхий нийтийг хамарсан цар тахал Ковид-19 өвчний дэгдэлт, хорио цээрийн нөхцөл байдалтай шууд холбоотой юм.
- 2020 онд Register бүртгэлийн программаас хасуулахаар хүсэлт гаргасан Монгол цэргийн музейн 6 дэсийн 8 ширхэг, Төв аймгийн музейн аймгийн 16 дэсийн 19 ширхэг үзмэр, нийт 22 дэсийн 27 ширхэг үзмэрийн материалын бүрдлийг судлан үзсэний үндсэн дээр цахим программаас хассан болно.
- Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тайланг маягтын дагуу хийж ирүүлэх ажил улс, аймгийн музейд харьцангуй тогтворжсон байгаа боловч эрдэм шинжилгээний байгууллагууд үйл ажиллагааны чиглэл нь музейгээс ялгаатай, хариуцсан ажилтнууд нь жил бүр өөрчлөгдөж байгаа зэргээс тайланг хугацаанд нь ирүүлэхгүй байх, тоон мэдээллийг дутуу болон зөрөөтэй оруулах, тайлангийн маягыг засаж өөрчлөх явдал байсаар байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нэгдсэн мэдээг 21 аймаг, нийслэлийн БМСангаас “Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээлэл”-ийг Маягт №1-В-аар, Монголын үндэсний музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Ховд Их сургууль, Улаанбаатарын Их сургууль, Дэлхийн өв-Бурхан Халдун уул, ТХТГНХЗ зэрэг 11 байгууллагаас “Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгааны ажлын 2020 оны мэдээлэл”-ийг Маягт №3-ын дагуу тус, тус авч дүн мэдээг нэгтгэв.

1. Аймаг, нийслэлийн БМСангаас ирүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дүн мэдээний нэгтгэл: Маягт №1-В буюу “Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээлэл”-ийг 19 аймаг, нийслэлийн (Нийслэлийн Соёл, урлагийн газар) БМСан, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа (ДӨ-ОХСДГХЗ) зэрэг газрууд ирүүлсэн байна. Үүнээс:

- Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг 2 аймгийн БМСан үл хөдлөх дурсгалын баяжилт, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй тухайгаа албан бичгээр мэдэгдсэн.
- 2020 онд нийт 19 аймаг, нийслэлийн БМС, ДӨ-ОХСДГХЗ зэрэг 21 газраас ирүүлсэн мэдээгээр нийт түүх, соёлын 12990 үл хөдлөх дурсгалын баяжилт болон шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна. Үүнд:
 - 12 аймаг, нийслэлийн БМСан, ДӨ-ОХСДГХЗ газарт түүх, соёлын үл хөдлөх 217 дурсгалт газрын 480 дурсгал шинээр бүртгэгдсэн.
 - 11 аймаг, нийслэлийн бүс нутгийн 17 дурсгалт газар судалгаа шинжилгээнд хамрагдсан,
 - 4 аймаг, ДӨ-ОХСДГХЗ газрын 33 дурсгалт газарт эх төрхийг сэргээн засварласан, дурсгалын цэвэрлэгээ, хамгаалалтын хашаа, хайс барьсан зэрэг хамгаалах арга хэмжээ авсан,
 - 5 аймагт 402 дурсгалыг гэрээт харуулд хариуцуулсан,
 - 21 аймаг, нийслэлийн 607 дурсгал “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д, 7 аймаг 11123 дурсгалыг “Сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д тус, тус хамруулжээ.
 - Нийслэлд 3 дурсгал гэмтсэн, 6-н аймагт 104 дурсгал тоногдсон, 3-н аймагт 4 дурсгал зөөгдсөн, зэрэг шалтгаанаар нийт 111 дурсгал эрсдэлд орсон тухай дүн гарч байна (Хүснэгт№4, Зураг №3).

Хүснэгт №4. Аймаг, нийслэлийн соёлын өвийн БМСангаас ирүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2020 оны тоон дүнгийн нэгдсэн үзүүлэлт.

№	Аймаг, нийслэл, байгууллага	Аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалын тоо		Судалгаа шинжилгээнд хамрагдсан үл хөдлөх дурсгалын тоо	Хамгаалах арга хэмжээ авсан үл хөдлөх дурсгалын тоо	Гэрээт харуулд хариуцуулсан үл хөдлөх дурсгалын тоо	Хамгаалалтын зэрэглэл тогтоогдсон үл хөдлөх дурсгалын тоо		Гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн үл хөдлөх дурсгалын тоо			Нийт
		Дурсгалт газар	Дурсгал				"Аймаг, нийслэлийн хамгаалалт-д авсан	"Сум, дүүргийн хамгаалалт-д авсан	Гэмтсэн	Тоногдсон	Зөөгдсөн	
1	Архангай	2	67	1		32	39	2279				2420
2	Баян-Өлгий						33	4141				4174
3	Баянхонгор					10	54			1		65
4	Булган					1	41	1130			1	1173
5	Говь-Алтай	11	11				33			3		58
6	Говьсүмбэр			1	4	10	3	273				291
7	Дархан-Уул						2					2
8	Дорноговь			1			27			75		103
9	Дорнод	1	1	1			31					34
10	Дундговь	154	231				37			20		442
11	Завхан	3	3	2	7		23					38
12	Орхон	1	1					111				113
13	Өвөрхангай	8	12	1	18	349	72					460
14	Өмнөговь						35					35
15	Сүхбаатар	15	120				24				2	161
16	Сэлэнгэ						23					23
17	Төв			1			24	1127			1	1153
18	Увс	3	4				10	2062				2079
19	Ховд	13	22	6			18					59
20	Хөвсгөл	1	1	1	1		31			1		36
21	Хэнтий	1	3	1			33			4		42
22	Нийслэл	1	1	1			14		3			20
23	ДӨ- ОХСДГХЗ	3	3		3							9
	Нийт	217	480	17	33	402	607	11123	3	104	4	12990

Зураг №3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2020 оны тоон дүнгийн график үзүүлэлт.



Аймаг, нийслэлийн БМСангаас авч буй “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээ авах Маягт №1-В”-ийн үндсэн асуулгад тухайн онд үл хөдлөх дурсгалтай холбоотой хийгдсэн бүхий л ажиллагааг хамруулахыг зорьсон билээ. Энэхүү Маягт №1-В нь үндсэн 7 асуулгатай бөгөөд асуулга тус бүрийг дэлгэрэнгүй хийсэн.

Аймаг, нийслэлийн хэмжээнд үл хөдлөх дурсгалтай холбоотой үйл ажиллагаа нь харилцан адилгүй учир Маягт №1-В-ийн дагуу ирүүлсэн мэдээллүүдийг үндсэн 7-н асуулгын дагуу тус бүрчлэн нэгтгэснийг танилцуулж байна. Дээрх Хүснэгт №4 толгой хэсэгт асуулга тус бүрийг дугаарлаж өгсөн болно.

Асуулга-1. Аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалын тоо.

2020 оны байдлаар Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 15 аймаг, нийслэлийн БМСан, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаанаас нийт 431 дурсгалт газрын, 1252 үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан мэдээ ирсэн.


Тэдгээрээс Говьсүмбэр аймгийн 1 дурсгалт газрын, 151 дурсгал, Дорноговь аймгийн 202 дурсгалт газрын, 621 дурсгал, Өмнөговь аймгийн 11 дурсгалт газар нийт 214 дурсгалт газрын, 772 дурсгал, өмнөх бүртгэлтэй дурсгалт газар дээр нэмж бүртгэсэн учир шинээр бүртгэсэн дурсгалын тоон дүнгийн нэгтгэлд оруулаагүй болно.

Аймаг, нийслэлийн БМСангаас ирүүлсэн 431 дурсгалт газрын, 1252 дурсгалаас Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгуудын бүртгэсэн 214 дурсгалт газрын, 772 дурсгал хасагдаж 2020 оны байдлаар 12 аймаг, нийслэл, ДӨ-ОХСДГХЗ зэрэг

газруудаас нийт 217 дурсгалт газрын 480 дурсгал шинээр бүртгэгдсэн байна. 2020 онд шинээр бүртгэгдсэн дурсгалыг аймаг тус бүрээр нэгтгэн үзвэл:

1. Архангай аймаг 2 дурсгалт газрын, 67 дурсгал,
2. Говь-Алтай аймаг 11 дурсгалт газрын, 11 дурсгал,
3. Дорнод аймаг 1 дурсгалт газрын 1 дурсгал,
4. Дундговь аймаг 154 дурсгалт газрын 231 дурсгал,
5. Завхан аймаг 3 дурсгалт газрын 3 дурсгал,
6. Орхон аймаг 1 дурсгалт газрын 1 дурсгал,
7. Өвөрхангай аймаг 8 дурсгалт газрын 12 дурсгал,
8. Сүхбаатар аймаг 15 дурсгалт газрын 120 дурсгал,
9. Увс аймаг 3 дурсгалт газрын 4 дурсгал,
- 10.Ховд аймаг 13 дурсгал газрын 22 дурсгал,
- 11.Хөвсгөл аймаг 1 дурсгал газрын 1 дурсгал,
- 12.Хэнтий аймаг 1 дурсгал газрын 3 дурсгал,
- 13.Нийслэл 1 дурсгалт газрын 1 дурсгал,
- 14.ДӨ-ОХСДГХЗ 3 дурсгалт газрын 3 дурсгал, нийт 217 дурсгалт газрын 480 дурсгал байна (Зураг №4).

Зураг №4. Аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн график үзүүлэлт



2020 онд шинээр үл хөдлөх дурсгал бүртгэсэн 12 аймаг, нийслэл, ДӨ-ОХСДГХЗ зэрэг газруудаас Архангай, Говь-Алтай, Дорнод, Завхан, Орхон, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн БМС, ДӨ-ОХСДГХЗ шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалыг RICH.03 программд бүртгэсэн бол Дундговь, Өвөрхангай, Увс аймгийн БМСан шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалуудыг RICH.03 программын бүртгэлд оруулаагүй байна.

Эндээс үзэхэд 2020 онд шинээр бүртгэгдсэн 480 дурсгалаас 233 дурсгалыг, үл хөдлөх дурсгалын RICH.03 программд бүртгэсэн, 247 дурсгалыг RICH.03 программд бүртгээгүй байна (Хүснэгт №5).

Хүснэгт №5. 2020 онд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалыг RICH.03 программд бүртгэсэн үзүүлэлт

№	Аймаг, нийслэлийн БМС	2020 онд шинээр бүртгэсэн		Үүнээс RICH.03 программд:	
		Дурсгалт газрын тоо	Дурсгалын тоо	Бүртгэгдсэн	Бүртгэгдээгүй байгаа
1.	Архангай	2	67	67	
2.	Говь-Алтай	11	11	11	
3.	Дорнод	1	1	1	
4.	Дундговь	154	231		231
5.	Завхан	3	3	3	
6.	Орхон	1	1	1	
7.	Өвөрхангай	8	12		12
8.	Сүхбаатар	15	120	120	
9.	Увс	3	4		4
10.	Ховд	13	22	22	
11.	Хөвсгөл	1	1	1	
12.	Хэнтий	1	3	3	
13.	Нийслэл	1	1	1	
14.	ДӨ-ОХСДГХЗ	3	3	3	
Нийт		217	480	233	247

Асуулга-2. Судалгаа, шинжилгээнд хамрагдсан үл хөдлөх дурсгалын тоо:

2020 оны байдлаар Архангай 1, Говьсүмбэр 1, Дорноговь 1, Дорнод 1, Завхан 2, Өвөрхангай 1, Төв 1, Ховд 6, Хөвсгөл 1, Хэнтий 1, нийслэл 1 нийт 10 аймаг, Улаанбаатар хот зэрэг 11 аймгийн бүс нутагт 17 дурсгалт газар судалгаа шинжилгээнд хамрагдсан мэдээ ирүүлсэн байна (Хүснэгт №6).

Хүснэгт №6. 2020 онд судалгаа шинжилгээнд хамрагдсан үл хөдлөх дурсгал

№	Аймаг	Сум	Дурсгалт газрын нэр	Судалгаа хийсэн байгууллага	Судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгалт газрын тоо
1.	Архангай	Өлзийт	Харганы дөрвөлжин	Улаанбаатарын Их сургууль	1
2.	Говь-Сүмбэр	Сүмбэр	Өвөр дэлгэр	ШУА-ийн Археологийн хүрээлэн	1
3.	Дорноговь	Хатанбулаг	Хатанбулаг	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн	1

4.	Дорнод	Цагаан-Овоо	Дэрэвийн арын манхны дурсгалт газар	ШУА-ийн Археологийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв	1
5.	Завхан	Яруу	Гол модны давааны Нууртын ам	Завхан аймгийн музей	2
		Тэс	Дооно баг, Сүмийн туурь	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн	
6.	Өвөрхангай	Баян-Өндөр	Баян-Өндөр	ШУА-ийн Археологийн хүрээлэн	1
7.	Төв	Мөнгөн морьт	Сарьдагийн хийд	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн	1
8.	Ховд	Зэрэг, Мянгад, Буянт	Зэрэг, Мянгад, Буянт	Ховд аймгийн музей, ХИС	6
9.	Хөвсгөл	Улаан-Уул, Рэнчинлхүмбэ	Хориг уул, Их номт уул, Бага номт уул, Доод цахир ууланд	Соёлын өвийн Үндэсний төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний Музей, ШУТИС	1
10.	Хэнтий	Дэлгэрхаан	Хэрлэнбаян улаан - Уулын Ханзат	ШУА-ийн Археологийн хүрээлэн, Чингис хааны өв соёлын хүрээлэн	1
11.	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	19-р хороо	БСШУСЯ, ЗГХА, Соёл, урлагийн газар, ШУА-ийн Археологийн хүрээлэн	1
Нийт					17

Асуулга-3. Хамгаалах арга хэмжээ авсан үл хөдлөх дурсгалын тоо: 2020 оны байдлаар Говьсүмбэр 4, Завхан 7, Өвөрхангай 18, Хөвсгөл 1, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа 3 нийт 4 аймаг, 1 байгууллага, харьяалах бүс нутагтаа байрлах 33 үл хөдлөх дурсгал дээр хамгаалах арга хэмжээ авсан байна. Хамгаалах арга хэмжээ авсан дурсгалыг нэгтгэн авч үзвэл:

- *Эх төрх байдлыг сэргээн засварласан:* Завхан аймаг 1 дурсгал,
- *Орчны цэвэрлэгээ хийсэн:* Говьсүмбэр 3, Завхан 3, нийт 6 дурсгалд,
- *Хашаа хайс барьсан:* Говьсүмбэр 1, Завхан 3, Өвөрхангай 11, Хөвсгөл 1, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа 3, нийт 19 дурсгал дээр хашаа хайс татсан,
- *Кадастрын зураглалд Өвөрхангай 7 дурсгал хамруулж хамгаалах арга хэмжээ авсан байна (Хүснэгт №7).*

Хүснэгт №7. 2020 онд хамгаалах арга хэмжээ авсан үл хөдлөх дурсгалын тоон үзүүлэлт

№	Аймаг	Эх төрх байдлыг сэргээн засварласан	Орчны цэвэрлэгээ хийсэн	Хашаа хайс барьсан	Кадастрын зураглалд хамруулсан
1.	Говьсүмбэр		3	1	
2.	Завхан	1	3	3	
3.	Өвөрхангай			11	7
4.	Хөвсгөл			1	
5.	ДӨ-ОХСДГХЗ			3	
Нийт		1	6	19	7


Асуулга-4. Гэрээт харуулд хариуцуулсан үл хөдлөх дурсгалын тоо: 2020 онд Архангай 32, Баянхонгор 10, Булган 1, Говьсүмбэр 10, Өвөрхангай 349 зэрэг 5 аймаг нийт 402 үл хөдлөх дурсгалыг гэрээт харуултай болгож, хамгаалалтын арга хэмжээ авчээ (Зураг №6).

Зураг №6. Гэрээт харуулд хариуцуулсан 5 аймгийн 402 үл хөдлөх дурсгалын тоон үзүүлэлт.



Асуулга-5. Хамгаалалтын зэрэглэл тогтоогдсон үл хөдлөх дурсгалын тоо: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д 607 үл хөдлөх дурсгалыг баталсан байна (Зураг №7).


Зураг №7. “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д орсон 607 үл хөдлөх дурсгалын тоон үзүүлэлт (аймгаар).



Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15.2 дугаарт зүйл: “...Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталж, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг тогтоон хяналт тавина.” гэж заасны дагуу 2020 оны байдлаар Архангай 2279, Баян-Өлгий

4141, Булган 1130, Говьсүмбэр 273, Орхон 111, Төв 1127, Увс 2062 нийт 7 аймаг 11123 үл хөдлөх дурсгалыг сум, дүүргийн хамгаалалтад авсан мэдээ ирүүлжээ (Зураг №8).

Зураг №8. “Сум, дүүргийн хамгаалалтад хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д орсон үл хөдлөх дурсгалын тоон үзүүлэлт. 2020 оны байдлаар.



Асуулга-6. Гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн үл хөдлөх дурсгалын тоо: 2020 оны байдлаар: Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэл зэрэг 10 газраас нийт 111 дурсгал гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн тухай мэдээлэл ирүүлсэн байна. Дурсгалуудыг ангилан авч үзвэл:

- *Гэмтсэн дурсгал:* Нийслэлийн Соёл, урлагийн газраас МУИС-ийн хашаанд байсан 3 дурсгал гэмтсэн хэмээн мэдээлэл өгсөн.
- *Тоногдсон дурсгал:* Дорноговь 75, Дундговь 20, Хэнтий 4, Говь-Алтай 3 Баянхонгор 1, Хөвсгөл 1 нийт 104 дурсгал тоногдсон.
- *Зөөгдсөн дурсгал:* Сүхбаатар 2, Булган 1, Төв 1 нийт 4 дурсгал зөөгдсөн буюу байршил өөрчлөгдсөн байна (Хүснэгт №7). Тухайн зөөгдсөн 4 дурсгалаас Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт байрлах Таван толгойн хүн чулуу, Булган аймгийн Сайхан сумын нутагт байрлах Могойн шинэ усны гэрэлт хөшөөдийг, “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Соёлын сайдын 2020 оны А/15 дугаар тушаалаар, зөөж тээвэрлэн Соёлын өвийн үндэсний төвийн байранд байршуулсан.

Хүснэгт №7. 2020 онд гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн.

№	Аймаг, нийслэл	Гэмтсэн дурсгал	Тоногдсон дурсгал	Зөөгдсөн дурсгал
1	Баянхонгор		1	
2	Булган			1
3	Говь-Алтай		3	
4	Дорноговь		75	
5	Дундговь		20	
6	Сүхбаатар			2
7	Төв			1
8	Хөвсгөл		1	
9	Хэнтий		4	
10	Нийслэл	3		

	Нийт	3	104	4
--	------	---	-----	---

2. Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль зэрэг судалгааны байгууллагаас ирүүлсэн эрдэм шинжилгээ, авран хамгаалах хайгуул, малтлага, судалгааны ажлын мэдээллийн нэгтгэл:

2020 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийг Монголын үндэсний музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Ховд Их сургууль, Улаанбаатарын Их сургууль, Дэлхийн өв-Бурхан Халдун уул, ТХТГНХЗ зэрэг 11 байгууллагаас “Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгааны” Маягт №3-ын дагуу авч, тоон дүнг нэгтгэх ажлыг гүйцэтгэв.

ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн зэрэг 3-н байгууллага дүн мэдээ ирүүлээгүй ба Палеонтологийн хүрээлэн 2020 онд цар тахал, хорио цээрийн дэглэмийн хайгуул судалгааны ажил хийгдээгүй тухайгаа албан бичгээр мэдэгджээ.


Мэдээллээ ирүүлсэн 8-н байгууллагын дүнг нэгтгэхэд:

- Эрдэм шинжилгээний судалгаагаар 341 дурсгал,
- Авран хамгаалах ажлаар 6725 дурсгал, нийт 2247 дурсгалт газрын 7066 дурсгал бүртгэн баримтжуулсан байна (Хүснэгт №9), (Зураг №7).

Хүснэгт №9. Эрдэм шинжилгээний байгууллагуудаас Маягт №3-ийн дагуу ирүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн нэгдсэн үзүүлэлт.


№	Байгууллагын нэр	Эрдэм шинжилгээний судалгаагаар илрүүлсэн үл хөдлөх дурсгалын тоо	Авран хамгаалах ажлаар илрүүлсэн үл хөдлөх дурсгалын тоо	Илрүүлсэн үл хөдлөх дурсгалын тоо	
				Дурсгалт газар	Дурсгал
1	ШУА-ийн Археологийн хүрээлэн	341	178	109	519
2	Монгол Улсын Их сургууль		122	8	122
3	Монголын үндэсний музей		135	8	135
4	ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн		265	11	265
5	Улаанбаатарын Их сургууль		3858	1794	3858
6	Ховд Их сургууль		638		638
7	Шинжлэх ухаан технологийн их сургууль		1516	317	1516
8	Дэлхийн өв-Бурхан халдун уул, ТХТГНХЗ		13		13
Нийт		341	6725	2247	7066

Зураг №7. Эрдэм шинжилгээний байгууллагуудаас 2020 онд авран хамгаалах ажлаар илрүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн график үзүүлэлт.



Дээрх 8-н байгууллагаас судалгааны болон авран хамгаалах ажлын хүрээнд илрүүлсэн үл хөдлөх дурсгалыг төрөл зүйлээр нь нэгтгэн авч үзвэл чулуун зэвсгийн дурсгалт газар, хадны зураг, бичгийн дурсгал, булш оршуулгын дурсгал, тахил тайлгын байгууламж, барилга архитектурын дурсгал, хөшөө дурсгал, үйлдвэрлэлийн ул мөр бүхий дурсгалт газар зэрэг төрөл зүйлийн дурсгал байгаагаас булш оршуулгын дурсгал хамгийн их тоон дүнг эзэлж байна (Зураг №8).

Зураг №8. 2020 онд судалгааны болон авран хамгаалах ажлын хүрээнд илрүүлсэн үл хөдлөх дурсгалыг төрөл зүйлийн үзүүлэлт.



2020 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн мэдээг 19 аймаг, нийслэлийн БМСан, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын

хамгаалалтын захиргаа, дээрх нэр бүхий эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль зэрэг 8-н байгууллага нийт 29 газраас ирүүлсэн дүнг нэгтгэхэд:

- 2020 оны байдлаар 19 аймаг, нийслэлийн БМСан, Дэлхийн өв- Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа зэрэг 21 газар нийт 217 дурсгалт газрын 480 дурсгал шинээр бүртгэсэн байна.


- Судалгаа шинжилгээнд хамрагдсан 17 дурсгалт газар, хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн 33 дурсгалт газар, гэрээт харуулд хариуцуулсан 402 дурсгал, “Сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д хамруулсан 11123 дурсгал, гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн зэрэг нийт 111 дурсгал байгаа тоон дүн мэдээг гаргалаа.

- 2020 онд нэр бүхий 8-н судалгааны байгууллагын авран хамгаалах ажлын хүрээнд 2247 дурсгалт газрын 7066 үл хөдлөх дурсгалыг илрүүлэн, бүртгэн баримтжуулсан байна.

- Аймаг, нийслэлийн БМСан болон эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль зэрэг судалгааны байгууллагаас 2020 оны авран хамгаалах ажлын хүрээнд илрүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүнг нэгтгэхэд анхаарах зүйл гарч байна. Үүнд:

Үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнгийн байршлыг сольж ирүүлсэн алдаа нийтлэг байгааг хэлэх хэрэгтэй. Дурсгалт газар гэдэг нь дурсгал байрлаж буй газрыг хэлнэ, тухайн дурсгалт газар дээр хэдэн ч тооны дурсгал байж болно. Жишээ нь: дараах зураг дээр Төв аймгийн Цээл сумын нутагт орших “Шийтэр” хэмээх нэг дурсгалт газар 200 орчим дурсгал байна (Зураг №9).

Зураг №9. Дурсгалт газар, дурсгалын жишээ




Судалгааны байгууллагын илрүүлсэн дурсгалуудаас аймгийн БМСанд бүртгэгдсэн бүртгэлтэй давхардсан газар цөөнгүй байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутгаас ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судалгааны багийн бүртгэн баримтжуулсан дурсгалын ихэнх хэсэг нь тус аймгийн БМСанд

бүртгэлтэй байна. Иймд давхардаж бүртгэгдсэн дурсгалуудыг шалгаж цэгцлэх шаардлага гарч байна.

- Цаашид дүн мэдээг тухайн онд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын мэдээллийг RICH.03 программд бүртгэгдэж орсоноор нь авч байх нь зүйтэй байна. Ингэснээр үл хөдлөх дурсгал улсын бүртгэлийн дугаар авч, давхар бүртгэгдэхээс сэргийлэх боломжтой болох юм (Зураг №10).

Зураг №10. Дурсгалыг RICH.03 программд бүртгэх тухай



Цаашид бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн авах, нэгтгэх мэдээний маягтыг сайжруулж улам боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ

Соёлын өвийн БМСангийн 2020 оны Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тайланг Маяг №1-С (1. Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн 2020 оны мэдээлэл, 2. Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн, 3. Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн, 4. Аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн) -ын дагуу 21 аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, нийслэл (9 дүүрэг)-ийн Соёл, урлагийн газар, нийт 22 байгууллагаас авч тоон дүнг нэгтгэн гаргав.

Тайлан ирүүлсэн аймаг, нийслэлийн 22 БМСангаас ирүүлсэн дүнг нэгтгэхэд:

- Баян-Өлгий, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл зэрэг 4 аймагт Соёлын биет бус өвлөн уламжлагчдийн 2019 оны суурь түвшиний тоон дүнд ямар нэг өөрчлөлт ороогүй;

- 8 аймгийн БМСангийн бүртгэлээс 199 өвлөн уламжлагч хасагдсан;

- 13 аймаг, нийслэлийн БМСанд 632 өвлөн уламжлагчид нэмэгдэж бүртгэгдсэн үзүүлэлттэй байна.

Бүртгэлээс хасагдсан өвлөн уламжлагчдийн талаар: УНБМСанд анхан шатны байдлаар бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагчийн тоон дүнг нэгтгэхэд Архангай 19, Булган 10, Баянхонгор 24, Говьсүмбэр 11, Дархан-Уул 5, Завхан 16, Сүхбаатар 2, Төв 112, нийт 8 аймгийн 199 өвлөн уламжлагчид “Шилжсэн”, “Шалгуурт тэнцээгүй”, “Нас барсан” гэсэн шалтгаанаар тухайн аймгийн БМСангийн бүртгэлээс хасагдсан байна (Хүснэгт №10).

Нэмэгдсэн өвлөн уламжлагчдийн талаар: Баянхонгор 8, Говь-Алтай 49, Говьсүмбэр 12, Дорнод 38, Дорноговь 67, Дундговь 15, Орхон 6, Өвөрхангай 2, Өмнөговь 41, Сүхбаатар 45, Увс 19, Хэнтий 88, Улаанбаатар хот 186 зэрэг 13 аймаг, нийслэлд нийтдээ **632** өвлөн уламжлагчаар нэмэгдсэн байна (Хүснэгт №10).


Хүснэгт №10. Аймаг, нийслэлийн БМСанд анхан шатны байдлаар бүртгэгдсэн 2020 оны соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тоон дүн

№	Аймаг, нийслэл	2019 оны тоон дүн	Хасагдсан тоо	Нэмэгдсэн тоо	2020 оны нийт тоон дүн
1	Архангай	377	19		358
2	Баян-Өлгий	621			621
3	Булган	185	10		175
4	Баянхонгор	311	24	8	295

5	Говь-Алтай	600		49	649
6	Говьсүмбэр	319	11	12	320
7	Дархан-Уул	75	5		70
8	Дорнод	322		38	360
9	Дорноговь	402	48	67	421
10	Дундговь	344		15	359
11	Завхан	508	16	56	548
12	Орхон	209		6	215
13	Өвөрхангай	262		2	264
14	Өмнөговь	305		41	346
15	Сэлэнгэ	492			492
16	Сүхбаатар	253	2	45	296
17	Төв	605	112		493
18	Увс	401		19	420
19	Ховд	924			924
20	Хөвсгөл	905			905
21	Хэнтий	615		88	703
22	Нийслэл	1429		186	1615
Нийт		10464	199	632	10849

Соёлын биет бусийн өвлөн уламжлагчдын тоо 2019 оны суурь түвшингөөс **385** өвлөн уламжлагчаар нэмэгдэж 2020 онд нийт **10849** болж **3.6** хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол суурь түвшний үзүүлэлтээс 199 хүн хасагдсаж 2 хувиар буурсан байна. Өсөлт болон буурсан үзүүлэлтийг зургаар харуулав (Зураг №11, 12).

Зураг №11. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн анхан шатны бүртгэлийн 2020 оны өсөлт УНБМСанд анхан шатны байдлаар бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагчийн тоон дүн.



Зураг №12. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн анхан шатны бүртгэлээс 2020 онд хасагдсан өвлөн уламжлагчийн тоон дүн.



2019 оны суурь түвшинд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-ийн хүрээнд 7 ай савын 250 (Хүснэгт №11) өвийн төрөл зүйл илэрсэн бол 2020 оны тайлан мэдээгээр шинээр өвийн төрөл зүйл илрээгүй байна.

Хүснэгт №11. Соёлын биет бус өвийн төрөл зүйлийн илэрц /2019 оны суурь түвшин/

№	Ай сав	Үндэсний жагсаалтын нэр	Дүн /2019 оны суурь түвшин/	Нийт дүн
1	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	35	40
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	5	
2	Ардын язгуур урлаг	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	44	57
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	13	

3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	35	49
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	14	
4	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	8	9
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	1	
5	Уламжлалт арга ухаан	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	28	31
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	3	
6	Мал маллах арга ухаан	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	7	7
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	0	
7	Уламжлалт гар урлал	Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	54	57
		Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл	3	
Нийт			250	

ДҮГНЭЛТ

2020 оны байдлаар соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар **10849** өвлөн уламжлагч бүртгэгдсэн бөгөөд 2019 оны суурь түвшинөөс 632 хүн буюу 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тоон дүнгээс харахад өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааны ажил урьд оны тоон дүн, тайлан мэдээтэй харьцуулахад өвлөн уламжлагчийн тоо 3.6 хувь өссөн, өвийн илэрц 0 хувийн үзүүлэлттэй байгаа нь өвлөн уламжлагчийг олж илрүүлэх, бүртгэх ажил хангалтгүй хийгдэж байгаа нь харагдаж байна.

Мөн энэхүү тайланд дурдсан аймгуудын ирүүлсэн мэдээнээс харахад 2020 онд Баян-Өлгий, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймгууд өвлөн уламжлагчийн бүртгэлд ямар нэг

баяжилтын мэдээлэл хийгээгүй, Архангай, Булган, Дархан-Уул, Төв аймгуудын өвлөн уламжлагчийн тоо зөвхөн хасагдсан үзүүлэлттэй байгаа бол Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Орхон, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Өвөрхангай, Увс, Хэнтий аймаг, нийслэлийн өвлөн уламжлагчийн тоо нэмэгдсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

СӨБСГАЗРЫН ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН САНЧ Ш.ЭНХТУЯА

СӨБСГАЗРЫН БҮРТГЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН САНЧ Ж.НАСАНЖАРГАЛ

СӨБСГАЗРЫН БҮРТГЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН САНЧ Б.АМГАЛАНБАТ

ХЯНАСАН:

СӨБСГАЗРЫН ДАРГА Д.НАРАНТУЯА